**БАТЛАВ: ХХААГАЗРЫН ДАРГА Н.ГАНТУЛГА**

**БАГЦ: 3. ТӨМСНИЙ ҮР АРИУТГАГЧ УРГАМАЛ ХАМГААЛАХ ХИМИЙН БОДИС**
**Төсөвт өртөг 20.000.000 төгрөг**

1. Монгол улсад 2024 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалтад бүртгэгдсэн, газар тариалангийн зориулалтаар ашиглаж болох түүнтэй дүйцэх төмсний мөөгөнцрийн өвчний эсрэг төмсний үр ариутгах ургамал хамгаалах химийн бодис нийлүүлнэ.

2. Ургамал хамгаалах химийн бодис бордоо импортлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байна.

3. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс шинээр туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн пестицидийн нэр төрөл, лабораторийн дүнгийн талаар нотлох бичиг баримттай.

4. Худалдан борлуулж буй пестицидийн үйлчлэх бодисын агууламжийн хэмжээг тодорхойлуулсан байх.

5. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 10, 11, 12, 13, 14, 17 дугаар зүйлд заасны дагуу ургамал хамгаалах химийн бодис бордоог хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах устгахад тавих үндсэн шаардлагыг хангасан байх.

6. Тендерт оролцогч нь ургамал хамгаалах химийн бодис бордоо хадгалах зориулалтын агуулах нь Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах Ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан байх.

7. Төмсний үр ариутгах ургамал хамгаалах химийн бодисын техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв болохыг нотлох баримт бичгийг /үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан танилцуулга, зураг, сертификат г.м./ ирүүлнэ.

8. Нийлүүлэхээр санал болгож буй үр ариутгалын бодис нь чанарын шаардлага хангаж байгааг нотлох

а) ургамал хамгаалах химийн бодисын гарал үүсэл,

б) чанар аюулгүй байдал

в) үйлчлэх бодисын агууламж, бодисын найрлага, бүтэц

в) ургамал хорио цээрийн гэрчилгээний хуулбарыг албан ёсны баталгаат орчуулгын мэдээллийн хамт байна

10. үр ариутгалын бодисын технологи, зөвлөмж, үйлдвэрлэгчийн танилцуулга

- Төсөв 20.000.000 /Хорин сая/ төгрөг

Газар тариалангийн зориулалтаар ашиглах төмсний
үр ариутгах ургамал хамгаалах химийн бодис

| № | Үзүүлэлт | Нийлүүлэгчийн тодорхойлолт |
|---|---|---|
| 1. | Ерөнхий үзүүлэлтүүд<br>Ургамал хамгаалах химийн бодисын нэр:<br>- Гарал үүсэл:<br>- Үйлдвэрлэсэн он<br>- Үйлчлэх бодисын нэр, хувь, хэмжээ<br>- Худалдааны нэр<br>- Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/<br>- Зориулалт<br>- Хэрэглэх тун, норм, хэмжээг хаяг шошгын мэдээлэлд Орос, Англи, Монгол хэлний аль нэг дээр бичигдсэн байх | |
| 2. | *- Төмсний үр ариутгах ургамал хамгаалах химийн бодис:* Монгол улсад 2024 онд хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалтад бүртгэгдсэн.<br>*- Бүтээгдэхүүний чанарын шаардлага:* Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах Ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан байна. | |
| **Төмсний үр ариутгах ургамал хамгаалах химийн бодис** | | |
| | *1. Ургамал хамгаалах химийн бодисын шинж чанар*:<br>- Үйлчлэх бодисын нэр, хувь<br>- Найрлага<br>- Хэрэглэх тун, хэмжээ<br>- Зориулалт | |
| | *- Химийн бодисын савлагаа:* үйлдвэрийн савлагаатай нийлүүлэгчийн гарал үүсэл, компани хаяг, утасны дугаарыг тодоор бичиж наасан байна.<br>*- Хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт:* Нийлүүлэгч барааг Улаанбаатар хотод зориулалтын тээврийн хэрэгслэлээр тээвэрлэн авчирч, зориулалтын стандартын шаардлага хангасан агуулахад хадгалж, Захиалагчид хүлээлгэн өгөх ба Захиалагчаас олгосон зөвшөөрлийн бичгийн дагуу эцсийн хүлээн авагчид барааг хүлээлгэн өгнө. | |